



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 21

Мандалговь

**Б.Дариймааг албан тушаалд нэр
дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 5 дугаар хуралдааны шийдвэр, төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын комиссын 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Буянтын Дариймаа 90.4 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.


Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Дариймаагийн санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

780021046



**Дундговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар
хамгааллын хяналтын улсын байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн
Буянтын Дариймаагийн тухай дүгнэлт**

1. Б.Дариймаа нь 1978 онд Говь-Алтай аймгийн Төгрөг сумын төвд төрсөн. 42 настай. Эмэгтэй.
2. Боловсролын байдал: Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийг 2006-2012 онд бакалавр зэрэгтэй, хүний их эмчийн мэргэжлээр суралцаж төгссөн.
3. Ажлын туршлага: 2012-2017 онд Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газарт Эрүүл мэндийн статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, 2017-2020 онд Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн статистикч их эмчээр ажиллаж байсан.
4. Б.Дариймаа нь төрийн захиргааны албанд ажиллаж байсан ажлын дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ